



МОНГОЛ УЛСЫН  
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2020 оны 4 сарын 07 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2020 оны 04 сарын 21-ны  
өдрийн 4768 дугаарт бүртгэв.

Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан,  
нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагчийг бүртгэх,  
үнэмлэх олгох журам батлах тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.6 дахь хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.6 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос ТОГТООХ нь:

1. "Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагчийг бүртгэх, үнэмлэх олгох журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтны үнэмлэх, нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагчийн үнэмлэх"-ийн загварыг 2 дугаар хавсралтаар, "Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтны бүртгэл"-ийн маягтыг 3 дугаар хавсралтаар, "Нэр дэвшигчийн менежерийн бүртгэл"-ийн маягтыг 4 дүгээр хавсралтаар, "Нэр дэвшигчийн шадар туслагчийн бүртгэл"-ийн маягтыг 5 дугаар хавсралтаар, "Нэр дэвшигчийн ухуулагчийн бүртгэл"-ийн маягтыг 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга нарт, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хорооны нарийн бичгийн дарга /Ц.Болдсайхан/-д тус тус даалгасугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн "Сонгуулийн штабын ажилтан, менежер, шадар туслагч, ухуулагчийн өдөр тутмын үйл ажиллагааны зардал гаргуулах журам батлах тухай" 08 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА


Ч. СОНДОМЦЭРЭН

Ч.СОДНОМЦЭРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ц.БОЛДСАЙХАН

Ц.БОЛДСАЙХАН



000035

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны  
2020 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн  
17 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**НАМ ЭВСЛИЙН СОНГУУЛЬ ЭРХЭЛСЭН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН,  
НЭР ДЭВШИГЧИЙН МЕНЕЖЕР, ШАДАР ТУСЛАГЧ, УХУУЛАГЧИЙГ  
БҮРТГЭХ, ҮНЭМЛЭХ ОЛГОХ ЖУРАМ**

***Нэг. Нийтлэг үндэслэл***

1.1. Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагчийг бүртгэх, үнэмлэх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Нам эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагчаар 18 насанд хүрсэн, энэ журамд заасны дагуу бүртгүүлж, үнэмлэх авсан иргэнийг ажиллуулна.

1.3. Нам эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагчаар төрийн захиргааны, тусгай болон үйлчилгээний албан хаагч ажиллахыг хориглоно.

***Хоёр. Бүртгэх, үнэмлэх олгох***

2.1. Нам, эвслийг сонгуульд оролцуулахаар бүртгэснээс хойш сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан бүртгүүлэх тухай хүсэлтээ дараах байдлаар хүргүүлнэ:

*/Энэ хэсгийг 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн СЕХ-ны 48 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

2.1.1. улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтны үнэмлэх авах тухай хүсэлтийг Сонгуулийн ерөнхий хороонд;

2.1.2. аймаг, нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтны үнэмлэх авах тухай хүсэлтийг аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд;

2.1.3. сум, дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтны үнэмлэх авах тухай хүсэлтийг сум, дүүргийн сонгуулийн хороонд.

2.2. Нэр дэвшигчийг бүртгэсэн өдрөөс хойш нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагчаар бүртгүүлж үнэмлэх авах тухай хүсэлтээ дараах байдлаар хүргүүлнэ:

*/Энэ хэсгийг 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн СЕХ-ны 48 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

2.2.1. нэр дэвшигчийн менежер, шадар туслагчийн үнэмлэх авах тухай хүсэлтийг аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд;

2.2.2. ухуулагчийн үнэмлэх авах тухай хүсэлтийг сум, дүүргийн сонгуулийн хороонд.

2.3. Нам, эвсэл, нэр дэвшигч нь энэ журмын 2.1, 2.2-д заасан хүсэлтийн хамт дараах баримт бичгийг хүргүүлнэ:

2.3.1.сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагчаар ажиллуулах этгээдийн бүртгэлийг холбогдох маягтын дагуу;

2.3.2.иргэний үнэмлэхийн хуулбар.

2.4.Энэ журмын 2.1, 2.2-т заасны дагуу гаргасан хүсэлтийг хүлээн авсан сонгуулийн хороо 48 цагийн дотор нягтлан шалгаж, мөн журмын 1.2-т заасан шаардлага хангасан этгээдийг бүртгэж, үнэмлэх олгоно.

### **Гурав. Бусад**

3.1.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагчаар бүртгүүлсэн этгээдийг өөрчлөх тохиолдолд хүсэлтээ энэ журмын 2 дугаар зүйлд заасны дагуу гарган өмнө олгосон үнэмлэхийн хамт хүргүүлнэ.

3.2.Энэ журмын 3.1-д заасны дагуу хүргүүлсэн хүсэлтийг хүлээн авсан сонгуулийн байгууллага 48 цагийн дотор нягтлан шалгаж, мөн журмын 1.2-т заасан шаардлага хангасан этгээдийг бүртгэж, үнэмлэх олгоно.

3.3.Сонгуулийн тухай хууль тогтоомж болон энэ журамд заасныг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.



---oOo---

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны  
2020 оны 4 дугаар сарын 07 ны өдрийн  
17 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт

1. Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажлын үнэмлэх

..... СОНГУУЛЬ

**НАМ, ЭВСЛИЙН СОНГУУЛЬ  
ЭРХЭЛСЭН БАЙГУУЛЛАГЫН  
АЖИЛТНЫ ҮНЭМЛЭХ**



..... нь  
..... нам /эвсэл/-ын  
сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтнаар  
бүртгэгдсэн тул үнэмлэх олгов.

..... хорооны дарга

Тамга, тэмдэг

/...../

20 ... оны ... сарын ... өдөр хүртэл хүчинтэй

Ар тал

2. Нэр дэвшигчийн менежерийн үнэмлэх

..... СОНГУУЛЬ

**НЭР ДЭВШИГЧИЙН  
МЕНЕЖЕРИЙН  
ҮНЭМЛЭХ**

Улаанбаатар / Дугаар .....

..... нь  
..... сонгуульд  
..... нам /эвсэл/-аас  
.....-ын  
нэр дэвшигч  
менежерээр бүртгэгдсэн тул үнэмлэх олгов.

.....  
сонгуулийн хорооны дарга  
1117 153152 9128719  
УХА0306



Тэмдэг

Ар тал

### 3. Шадар туслагчийн үнэмлэх

..... **СОНГУУЛЬ**

## ШАДАР ТУСЛАГЧИЙН ҮНЭМЛЭХ



сонгульд

.-нам /эвсэл/-аас нэр дэвшигч

**-ын шадар туслагчаар**

бүртгэгдсэн тул үнэмлэх олгов.

**сонгуулийн хорооны дарга**

### Тэмдэг

1.....



20 ... оны ... сарын ... өдөр хүртэл хүчинтэй

Ар тал


4. Ухуулагчийн үнэмлэх

..... СОНГУУЛЬ

НЭР ДЭВШИГЧИЙН  
УХУУЛАГЧИЙН ҮНЭМЛЭХ



1117 153152



..... нам /эвсэл/-аас нэр дэвшигч  
.....-ын ухуулагчаар  
ажиллахаар бүртгэгдсэн тул үнэмлэх олгов.


..... сонгуулийн хорооны дарга

Тэмдэг

/...../

20 ... оны ... сарын ... өдөр хүртэл хүчинтэй

Ар тал



Монгол Улсын Сонгуулийн хорооны  
2020 оны 17 дугаар тоглогчийн өдрийн  
17 дугаар тоглогчийн дугаар хавсралт

Сонгуулийн төрөл:.....  
Нам, эвслийн нэр:.....

### НАМ, ЭВСЛИЙН СОНГУУЛЬ ЭРХЭЛСЭН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫ БҮРТГЭЛ


| № | Эцэг /эх/-ийн болон өөрийн нэр | Регистрийн дугаар | Ажил, албан тушаал | Харилцах утас, хаяг | Сонгуулийн хороонд бүртгүүлсэн огноо <sup>1</sup> | Үнэмлэхийн дугаар |
|---|--------------------------------|-------------------|--------------------|---------------------|---------------------------------------------------|-------------------|
|   |                                |                   |                    |                     |                                                   |                   |
|   |                                |                   |                    |                     |                                                   |                   |
|   |                                |                   |                    |                     |                                                   |                   |
|   |                                |                   |                    |                     |                                                   |                   |
|   |                                |                   |                    |                     |                                                   |                   |
|   |                                |                   |                    |                     |                                                   |                   |

1117 153152 9128719  
УХА0306

Тамга, тэмдэг ..... хорооны нарийн бичгийн дарга /...../

..... он ..... сар ..... өдөр

1. Сонгуулийн хороонд бүртгүүлсэн огноо, үнэмлэхийн дугаар хэсгийг тухайн сонгуулийн хароо бүртгэнэ.



Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны  
2020 оны 4 дугаар сарын 27-ны өдрийн  
17 дугаар тогтоолыг үзгээр хавсралт

Сонгуулийн төрөл:.....  
Нам, эвслийн нэр:.....  
Нэр дэвшигчийн тойргийн дугаар:.....  
Нэр дэвшигчийн овог нэр:.....


НЭР ДЭВШИГЧИЙН МЕНЕЖЕРИЙН БҮРТГЭЛ

| № | Эцэг /эх/-ийн болон өөрийн нэр | Регистрийн дугаар | Ажил, албан тушаал | Харилцах утас, хаяг | Сонгуулийн хороонд бүртгүүлсэн огноо | Үнэмлэхийн дугаар |
|---|--------------------------------|-------------------|--------------------|---------------------|--------------------------------------|-------------------|
|   |                                |                   |                    |                     |                                      |                   |
|   |                                |                   |                    |                     |                                      |                   |
|   |                                |                   |                    |                     |                                      |                   |
|   |                                |                   |                    |                     |                                      |                   |
|   |                                |                   |                    |                     |                                      |                   |
|   |                                |                   |                    |                     |                                      |                   |

1117 153152 9128719  
УХА0306

Тэмдэг ..... сонгуулийн хорооны дарга ..... он ..... сар ..... өдөр /...../

1 Сонгуулийн хороонд бүртгүүлсэн огноо, үнэмлэхийн дугаар хэсгийг тухайн сонгуулийн хороо бүртгэнэ.



Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны  
2020 оны 4 дугаар сарын 17-ны өдрийн  
17 дугаар сарын 17-ны өдрийн хавсралт

Сонгуулийн төрөл:.....  
Нам, эвслийн нэр:.....  
Нэр дэвшигчийн тойргийн дугаар:.....  
Нэр дэвшигчийн овог нэр:.....


### НЭР ДЭВШИГЧИЙН ШАДАР ТУСЛАГЧИЙН БҮРТГЭЛ

| № | Эцэг /эх/-ийн болон<br>өөрийн нэр | Регистрийн дугаар | Ажил, албан тушаал | Харилцах утас, хаяг | Сонгуулийн хороонд<br>бүртгүүлсэн огноо | Үнэмлэхийн<br>дугаар |
|---|-----------------------------------|-------------------|--------------------|---------------------|-----------------------------------------|----------------------|
|   |                                   |                   |                    |                     |                                         |                      |
|   |                                   |                   |                    |                     |                                         |                      |
|   |                                   |                   |                    |                     |                                         |                      |
|   |                                   |                   |                    |                     |                                         |                      |



Тэмдэг ..... сонгуулийн хорооны дарга ..... 9128719  
1117 153152 УХА0306  
/..... сар ..... өдөр

1. Сонгуулийн хороонд бүртгүүлсэн огноо, үнэмлэхийн дугаар хэсгийг тухайн сонгуулийн хороо бүртгэнэ.




Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны  
2020 оны 4 дугаар сарын 17-ны өдрийн  
17 дугаар дотоод дугаар хавсралт

Сонгуулийн төрөл:.....  
Нам, эвслийн нэр:.....  
Нэр дэвшигчийн тойргийн дугаар:.....  
Нэр дэвшигчийн овог нэр:.....

### НЭР ДЭВШИГЧИЙН УХУУЛАГЧИЙН БҮРТГЭЛ

| № | Эцэг /эх/-ийн болон<br>өөрийн нэр | Регистрийн дугаар | Ажил, албан<br>тушаал | Харилцах угас, хаяг | Сонгуулийн хороонд<br>бүртгүүлсэн огноо | Үнэмлэхийн дугаар |
|---|-----------------------------------|-------------------|-----------------------|---------------------|-----------------------------------------|-------------------|
|   |                                   |                   |                       |                     |                                         |                   |
|   |                                   |                   |                       |                     |                                         |                   |
|   |                                   |                   |                       |                     |                                         |                   |
|   |                                   |                   |                       |                     |                                         |                   |
|   |                                   |                   |                       |                     |                                         |                   |
|   |                                   |                   |                       |                     |                                         |                   |
|   |                                   |                   |                       |                     |                                         |                   |



Тэмдэг .....  
сонгуулийн хорооны дарга

/...../

..... он ..... сар ..... өдөр

1. Сонгуулийн хороонд бүртгүүлсэн огноо, үнэмлэхийн дугаар хэсгийг тухайн сонгуулийн хороо бүртгэнэ.